

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/10/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: У.Ербол Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Төлбөрийн акт	17
4.3 Албан шаардлага	17
4.4 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

**ХӨГЖИМТ ДРАМЫН ТЕАТРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ж.САЙГҮЛИК
ТАНАА**

2022.02.16 № 57
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөгжимт драмын театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн одог улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-Дүгнэлт

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	90,760,447.00	86,076,347.00
33	АВЛАГА	8,630,000.00	40,000.00
335	Бусад авлага	8,630,000.00	40,000.00
3351	Байгууллагаас авах авлага	8,630,000.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	40,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	82,130,447.00	86,036,347.00
354	Хангамжийн материал	82,130,447.00	86,036,347.00
35410	Бичиг хэргийн материал	130,500.00	130,500.00
35420	Аж ахуйн материал	28,061,707.00	30,178,657.00
35430	Сэлбэг хэрэгсэл	742,000.00	742,000.00
35470	Бусад хангамжийн материал	53,196,240.00	54,985,190.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,332,013,950.73	6,095,124,753.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,332,013,950.73	6,095,124,753.28
392	Биет хөрөнгө	6,181,053,950.73	5,943,219,753.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,328,073,700.96	6,328,073,700.96
39202	Хуримтлагдсан элэгдэл	(374,327,153.52)	(561,490,730.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,500,000.00	31,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(27,541,666.57)	(30,041,666.53)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	178,891,003.00	177,859,378.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(57,299,191.87)	(94,772,547.38)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	168,403,785.00	167,002,349.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(161,123,034.62)	(162,373,259.00)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	73,609,568.00	73,609,568.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	113,280,213.20	113,280,213.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	(92,413,272.85)	(99,427,252.69)
393	Биет бус хөрөнгө	150,960,000.00	151,905,000.00
39301	Програм хангамж	575,000.00	575,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(575,000.00)	(575,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	150,960,000.00	151,905,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,422,774,397.73	6,181,201,100.28
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	37,852,723.00	92,196,490.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	37,852,723.00	92,196,490.00
413	Өглөг	37,852,723.00	92,196,490.00
4136	Бусад өглөг	37,852,723.00	92,196,490.00
41361	Байгууллагад төлөх өглөг	35,262,723.00	92,196,490.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,590,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,384,921,674.73	6,089,004,610.28
51	Засгийн газрын хувь оролцоо	6,384,921,674.73	6,089,004,610.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,054,061,814.00	1,055,006,814.00
51101	Өмч: - төрийн	1,054,061,814.00	1,055,006,814.00
512	Хуримтлагдсан үр дүн	(907,421,437.15)	(1,204,283,501.60)
51210	Өмнөх үеийн үр дүн	(907,421,437.15)	(907,421,437.15)
51220	Тайланг үеийн үр дүн	-	(296,862,064.45)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,238,281,297.88	6,238,281,297.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,422,774,397.73	6,181,201,100.28

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,312,681,050.00	1,146,542,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,719,850.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	1,719,850.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,700,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,700,000.00	-
120009	Бусад орлого	19,850.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,310,961,200.00	1,146,542,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	114,863,100.00	-
131005	Хөрөнгийн санхүүжилт	114,863,100.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,338,000.00	37,702,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,579,800.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,758,200.00	37,702,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,186,760,100.00	1,108,840,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,186,760,100.00	1,108,840,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,404,262,667.64	1,443,404,964.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,404,262,667.64	1,443,404,964.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,374,296,025.64	1,438,748,811.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	685,080,922.00	667,440,176.00
210101	Үндсэн цалин	537,550,531.00	536,376,815.00
210102	Нэмэгдэл	112,990,815.00	99,850,211.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,539,576.00	31,213,150.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,478,628.00	86,864,830.00
210201	Тэтгэврийн даатгал	56,173,459.00	60,318,138.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,616,948.00	6,718,099.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,807,575.00	5,361,037.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,794,593.00	1,315,233.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,086,053.00	13,152,323.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	368,370,749.00	405,560,455.00
210301	Гэрэл, цахилгаан	5,201,149.00	5,414,888.00
210302	Түлш, халаалт	358,369,600.00	394,098,467.00
210303	Цэвэр, бохир ус	4,800,000.00	6,047,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,301,643.00	1,968,140.00
210401	Бичиг хэрэг	469,000.00	368,400.00
210402	Тээвэр, шатахуун	2,290,200.00	1,140,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	426,353.00	250,540.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	116,090.00	209,000.00
2105	Нормативт зардал	1,376,100.00	550,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,376,100.00	550,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,956,900.00	11,277,645.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	263,690.00	-
210604	Урсгал засвар	1,693,210.00	11,277,645.00
2107	Томиллолт, зочны зардал	-	-

Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,426,355.00	12,651,468.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,811,555.00	11,299,040.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	420,000.00	312,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	183,000.00	182,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	89,000.00	31,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	253,000.00	242,000.00
210807	Газрын төлбөр	603,800.00	517,578.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	227,304,728.64	252,435,197.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,924,360.00	14,601,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	225,380,368.64	237,834,197.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,966,642.00	4,656,153.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,072,100.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,572,100.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,894,542.00	4,656,153.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,894,542.00	4,656,153.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(91,581,617.64)	(296,862,064.45)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(91,581,617.64)	(296,862,064.45)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,054,061,814.00	6,238,281,297.88	-907,421,437.15		6,384,921,674.73
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,054,061,814.00	6,238,281,297.88	-907,421,437.15	0.00	6,384,921,674.73
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, савд					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,054,061,814.00	6,238,281,297.88	-907,421,437.15	0.00	6,384,921,674.73
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,054,061,814.00	6,238,281,297.88	-907,421,437.15	0.00	6,384,921,674.73
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,054,061,814.00	6,238,281,297.88	-907,421,437.15	0.00	6,384,921,674.73
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	945,000.00				945,000.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, савд					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-296,862,064.45		-296,862,064.45
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,055,006,814.00	6,238,281,297.88	-1,204,283,501.60	0.00	6,089,004,610.28

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,196,117,950.00	1,146,542,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,850.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	19,850.00	-
120009	Бусад орлого	19,850.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,196,098,100.00	1,146,542,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,338,000.00	37,702,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,579,800.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,758,200.00	37,702,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,186,760,100.00	1,108,840,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,186,760,100.00	1,108,840,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,196,284,800.00	1,146,542,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,196,284,800.00	1,146,542,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,166,238,158.00	1,141,886,747.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	685,435,397.00	667,971,961.00
210101	Үндсэн цалин	537,732,081.00	536,908,600.00
210102	Нэмэгдэл	113,163,740.00	99,850,211.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,539,576.00	31,213,150.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,478,628.00	86,864,830.00
210201	Тэтгэврийн даатгал	56,173,459.00	60,318,138.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,616,948.00	6,718,099.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,240,781.00	5,361,037.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,361,387.00	1,315,233.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,086,053.00	13,152,323.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	380,243,000.00	348,626,688.00
210301	Гэрэл, цахилгаан	5,201,149.00	4,982,588.00
210302	Түлш, халаалт	370,241,851.00	337,164,700.00
210303	Цэвэр, бохир ус	4,800,000.00	6,479,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,481,453.00	2,028,140.00
210401	Бичиг хэрэг	442,100.00	368,400.00
210402	Тээвэр, шатахуун	2,290,200.00	1,140,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	426,353.00	250,540.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	322,800.00	269,000.00
2105	Нормативт зардал	661,100.00	550,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	661,100.00	550,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,968,100.00	10,113,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	250,000.00	32,000.00
210604	Урсгал засвар	2,718,100.00	10,081,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,903,680.00	15,130,228.00

**Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,213,880.00	13,777,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	420,000.00	312,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	183,000.00	182,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	89,000.00	31,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	328,000.00	242,000.00
210807	Газрын төлбөр	603,800.00	517,578.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,066,800.00	10,601,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,066,800.00	10,601,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,046,642.00	4,656,153.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,072,100.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,572,100.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,894,542.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,894,542.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	80,000.00	4,656,153.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	80,000.00	4,656,153.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(166,850.00)	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,453,350.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,453,350.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	2,453,350.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,453,350.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(2,453,350.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(2,620,200.00)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,540,200.00	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,108,840,900.00	1,104,184,747.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,108,840,900.00	1,104,184,747.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,108,840,900.00	1,104,184,747.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	671,088,700.00	667,971,961.00
210101	Үндсэн цалин	536,908,600.00	536,908,600.00
210102	Нэмэгдэл	102,966,900.00	99,850,211.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,213,200.00	31,213,150.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,344,500.00	86,864,830.00
210201	Тэтгэврийн даатгал	60,923,900.00	60,318,138.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,855,200.00	6,718,099.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,484,100.00	5,361,037.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,371,000.00	1,315,233.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,710,300.00	13,152,323.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	334,126,700.00	334,126,688.00
210301	Гэрэл, цахилгаан	4,982,600.00	4,982,588.00
210302	Түлш, халаалт	322,664,700.00	322,664,700.00
210303	Цэвэр, бохир ус	6,479,400.00	6,479,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,028,200.00	2,028,140.00
210401	Бичиг хэрэг	368,400.00	368,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,140,200.00	1,140,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	250,600.00	250,540.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	269,000.00	269,000.00
2105	Нормативт зардал	550,900.00	550,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	550,900.00	550,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,000.00	32,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	32,000.00	32,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
210702	Дотоод албан томилолт		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,669,900.00	12,610,228.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	11,257,800.00	11,257,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	312,500.00	312,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	183,000.00	182,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	91,000.00	31,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	242,000.00	242,000.00
210807	Газрын төлбөр	517,600.00	517,578.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,108,840,900.00	1,104,184,747.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,108,840,900.00	1,104,184,747.00
132001	Орон нутгийн төсвөөс	1,108,840,900.00	1,104,184,747.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	67.00	67.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	53.00	53.00
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	67.0	67.0
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	54.00	53.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13.00	14.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансн	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,804,650.00	37,702,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,804,650.00	37,702,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,804,650.00	37,702,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	14,500,000.00
210302	Түлц, халаалт		14,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	579,800.00	-
210402	Тээвэр, шатахуун	579,800.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,718,100.00	10,081,000.00
210604	Урсгал засвар	2,718,100.00	10,081,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	2,520,000.00
210801	бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр		2,520,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,506,750.00	10,601,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,506,750.00	10,601,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,338,000.00	37,702,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,338,000.00	37,702,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,579,800.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,758,200.00	37,702,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Соёлын сайдын тушаал, шийдвэр, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэн үндэсний уламжлалт болон орчин үеийн соёл, урлагийг хөгжүүлэх, хүн төрөлхтний бүтээж буй болгосон соёл, урлагийг иргэдэд хүргэх, үндэсний урлаг, соёлын биет болон биет бус өвийг таниулан сурталчлах, уран бүтээлийн чанар, соёлын үйлчилгээг дээшлүүлэх, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж улмаар өөрийн зах зээлтэй болох зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хөгжимт драмын театрын 200-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдсэн ба зөрчил дутагдал илрээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1404.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 21.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 15.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөгжимт драмын театрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24.1 сая төгрөгөөр буюу 3.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	8630.00	40.0	-8590.00
Урьдчилгаа	0.00	0.00	0.0
Бараа материал	82130.4	86036.3	3905.9
Үндсэн хөрөнгө	6332013.9	6095124.7	-236889.2
Нийт хөрөнгө	6422774.4	6181201.1	-241573.3
Өр төлбөр	37852.7	92196.5	54343.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6384921.7	6089004.6	-295917.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6422774.4	6181201.1	-241573.3

Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна. Авлагын дансны үлдэгдэл 0.04 сая төгрөг болж буурсан нь түрээсийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 86.0 сая төгрөг болж 3.9 сая төгрөгөөр нэмэгджээ. Тайлант онд 20.3 сая төгрөгийн бараа материал худалдан авч үйл ажиллагаандаа 16.4 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6095.1 сая төгрөг болж 236.9 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 5.0 сая төгрөгийн хөрөнгийг биет бус төсвийн хөрөнгийг аймгийн Засаг даргын 2021 оны А/109 тоот захирамжаар орлого авч, аймгийн ИТХ-ын 2021 оны 36 тоот тогтоолоор Улсын бүртгэлийн газарт 4.0 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлсэн байна. Жилийн эцэст 2.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг аймгийн ИТХ-ын 2021 оны 18 тоот тогтоолоор акталсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 92.2 сая төгрөг болж 54.3 сая төгрөгөөр өссөн нь түлш халаалтын үнэ, тарифыг нэмсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6089.0 сая төгрөг болж 241.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 241.6 сая төгрөг буурсантай холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1146.5 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 166.1 сая төгрөгөөр буюу 12.6 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал санхүүжилтийн орлого, нэмэлт санхүүжилтийн орлого байна. Урсгал санхүүжилт өмнөх оноос 77.9 сая төгрөгөөр буурсан, нэмэлт санхүүжилтийн орлого 30.9 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 1143.4 сая төгрөгөөр буюу 2.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал, байр ашиглахтай холбоотой зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлууд байна. Байр ашиглахтай холбоотой зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал өмнөх оноос нэмэгдэж, цалингийн зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, урсгал шилжүүлгийн зардлууд өмнөх оноос буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны анх батлагдсан төсөв 1121.1 сая төгрөг, тодотгосон төсөв 1108.8 сая төгрөг байна. Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 18.3 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд:

Цалингийн зардлыг 14.4 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 4.2 сая, хангамж бараа материалын зардлыг 0.2 сая, албан томилолтын зардлыг 0.7 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 0.1 сая, бусад урсгал шилжүүлгийг 0.4 сая төгрөгөөр бууруулж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 1.5 сая, төгрөгөөр нэмж тодотгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1108.8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 1104.2 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг нийт дүнгээр 4.6 сая төгрөгөөр хэмнэж төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Энэ нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын хэмнэлт байна.

Цалингийн зардал 3.1 сая, НДШ-ийн зардал 1.5 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд түрээсийн орлогоос 37.0 сая, үзвэр үйлчилгээний орлогоос 0.7 сая, нийт 37.7 сая төгрөгийн орлого оруулж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр урсгал засварын зардалд 10.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 2.5 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 10.6 сая, түлш халаалтын өр төлбөрт 14.5 сая төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Хөгжимт драмын театр нь 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна. Байгууллага үйл ажиллагаатай холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдол гараагүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Нийт санхүүжилтийн орлого болох 1127.1 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлын 1100.7 сая төгрөгийг хасахад 26.4 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 2.6 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байна. Тус газар нь оны эцэст 4.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн тул Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажилласан байна гэж үзлээ.

Хөгжимт драмын театрын тайлант онд “Эрчим” ХХК-д халаалтын зардалд батлагдсан 337.1 сая төгрөгийг бүрэн төлсөн боловч оны эцэст 92.2 сая төгрөгийн өглөгтэй гарч өглөг оны эхнээс 61.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь халаалтын зардлын төсвийг төсөвт дутуу суулгасан, төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал байна.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөгжимт драмын театр нь 2021 онд нийт 1146.5 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1146.5 сая төгрөгийн 149 мэдээллийг хугацаандаа бүрэн байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түрээсийн гэрээгээр ажиллаж байгаа аж ахуйн нэгж, иргэдээс авах 8.6 сая төгрөгийн түрээсийн авлагыг барагдуулах талаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 1.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Театрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2021 оны Б/43 дугаар тушаалаар нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтан нарт нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний 1386.0 мянган төгрөгийн урамшууллыг үндсэн цалингаас ажил үүргийн биелэлт, гүйцэтгэлийн үр дүнг тооцохгүйгээр, бүрдэл дутуу баримтаар олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.2, 41.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 05 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 3 дугаар хавсралтын 1.3-т “Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг төсвийн байгууллага жил бүр төсөвтөө тусгана”, 2.5. Энэ журмын 2.4-т зааснаас бусад төрийн албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн олгоно”, 2.5-т “ Энэ журмын 2.4-т зааснаас бусад төрийн албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн олгоно”, 2.6-т “Төсвийн шууд захирагч энэ журамд нийцүүлэн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох нарийвчилсан журмыг баталж болно” гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Байхгүй

4.4 Зөвлөмж

1. Илрүүлэлт:

Баян-Өлгий аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 18 дугаар тогтоолоор 1.4 сая төгрөгийн тавилга эд хогшил, 1.0 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, нийт 2.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлах тухай зөвшөөрөл олгосон боловч өмч хамгаалах Байнгын зөвлөлөөр хэлэлцэж, дүгнэлт гаргуулаагүй, байгууллагын даргын шийдвэрээр акталж, устгал хийгээгүй байна.

2. Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийг хэрэгжүүлэн ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөгжимт драмын театр	2	3.8			1	1.4			1	2.4